



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/338

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1, Засгийн газрын 2016 оны 10, 2020 оны 152 дугаар тогтоол, 2024 оны 136 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XVIII хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдсан Мөрөн сумын 13 дугаар баг Радио өргөн нэвтрүүлэх станцын хажууд (урд) талд байршилтай 3818152 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний цахим дуудлага худалдаанд орж ялсан иргэн Тогоруутан овгийн Одхүүгийн Энхбат (РГ76090112)-д үйлдвэрлэлийн барилга, байгууламжийн газрын зориулалттай 4000м² газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч иргэн Одхүүгийн Энхбат (РГ76090112)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.



ДАРГА П.ЛХАГВАЖАВ

6712011046 Захирамж 2024